<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө /өмчийн дүн/</b>	<b>9,395,196.0</b>	<b>15,980,148.0</b>	<b>6,584,952.0</b>

Авлага данс 3,982,638.9 мянган төгрөгөөр буурсан нь хатуу хучилттай автозам 3,725,663.1 мянган төгрөг, ээж хайрхны тохижилтын ажлын 256,975.8 мянган төгрөгийн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал данс 81,375.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 60,035.9 мянган төгрөг, бусад хангамжийн материал 6,000.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 1,220.8 мянган төгрөг, аж ахуйн материал 14,212.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, сэлбэг хэрэгсэл 14,803.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь зудын эрсдэлтэй бүс нутагт эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 60,000.0 мянган төгрөгийн өвс, тэжээл нөөцөлснөөс шалтгаалж бараа материалын үлдэгдэл өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 15,980,148.0 мянган төгрөг болж, 6,522,915.3 мянган төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5,849,545.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандив тусламжаар 4,933,418.0 мянган төгрөг, дахин үнэлгээний бууралт 114,212.7 мянган төгрөг, нийт 11,112,361.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 29-ний А/18 дугаар тушаалаар орлогод авсан байна.

Үүнд: Төсвийн хөрөнгөөр:

- Барилга байгууламж дансанд 4ш худаг 80,424.7 мянган төгрөг, их засварт 59,460.0 мянган төгрөг, нийт 140,184.6 мянган төгрөгөөр,
- Машин тоног төхөөрөмж дансанд компьютер техник хэрэгсэл 15,414.7 мянган төгрөгөөр,
- Зам гүүрний байгууламж дансанд хатуу хучилттай автозам 5,115,742.5 мянган төгрөгөөр,
- Тавилга эд хогшил дансанд 40,800.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө дансанд наадмын талбайн хашаа 88,425.3 мянган төгрөг, Ээж хайрхны тохижилт 366,525.4 мянган төгрөгөөр тус тус худалдан авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.
- Аймгийн төсвийн санхүүжилтээр барилга байгууламж дансанд 2 ш худаг 37,299.6 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж дансанд цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж 27,000.0 мянган төгрөгөөр авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

Үнэ төлбөргүйгээр орлогод авсан:

- Барилга байгууламж дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар уурын зуухны барилга 4,299,855.9 мянган төгрөг, 6 ш худгийн гэрээний дүнгийн зөрүү сайжруулалт 4,744.7 мянган төгрөгөөр,
- Авто тээврийн хэрэгсэл дансанд Төв аймгийн ХХААГ-аас хуваарилсан 165 морины хүчтэй трактор 198,875.0 мянган төгрөгөөр,
- Бусад биет бус хөрөнгө дансанд ЗДТГ-т бүртгэлтэй 5 ширхэг газрыг 259,848.0 мянган төгрөгөөр,

- Машин тоног төхөөрөмжийн дансанд ХХААГ-аас хуваарилсан мал аж ахуйн тоног төхөөрөмж 25,850.0 мянган төгрөг, газар тариалангийн тоног төхөөрөмж 87,344.8 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас хуваарилсан тоног төхөөрөмж 9,724.5 мянган төгрөгөөр,
- Бусад үндсэн хөрөнгө дансанд Ээж хайрхны тохижилтын ажлын гэрээний дүнгийн зөрүү сайжруулалт 9,174.8 мянган төгрөгөөр тус тус орлогод авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 05-ны 50 дугаар тогтоолоор 99,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий Алфарт маркийн авто машиныг Гадаадын иргэн харьяатын газарт шилжүүлсэн байна. Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 16-ны 01/342 дугаар албан бичгээр авто тээврийн хэрэгслийн дансанд 2 ш 63,163.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж дансанд бүртгэлтэй 24 нэр төрлийн 78 ш 75,160.3 мянган төгрөг, тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй 11 нэр төрлийн 126 ш 23,991.5 мянган төгрөг, бусад хөрөнгийн дансанд бүртгэлтэй 16 нэр төрлийн 267 ш 166,356.5 мянган төгрөг, биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2ш 805.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг ашиглалтын хугацааг тус бүр 3 жилээр шинэчлэн нийт балансын дүнгийн 30 хувиар бууруулж нийт 329,398.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна. Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал 566,265.9 мянган төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 162,036.7 мянган төгрөг болж өссөн нь бараа материалын өглөг 16,420.7 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын өглөг 145,616.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Эдгээр өглөгүүд нь санхүүжилтыг 12 сард зарцааснаас үүссэн байна.

Хөрөнгө оруулалтын өглөг 145,616.1 мянган төгрөг нь 2 ш худгийн цооногийн ажлын үлдэгдэл 35,823.4 мянган төгрөг, Ээж хайрхны тохижилтийн ажлын үлдэгдэл 18,152.9 мянган төгрөг, цахим дэлгүүрээс авсан компьютер тоног төхөөрөмжийн үлдэгдэл 10,950.0 мянган төгрөг, авто замын зургийн 80,689.7 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлээс үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15,980,148.0 мянган төгрөг болж 6,584,952.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**Программ хангамжийн бүртгэл, тайлагнал:** Тус байгууллага нь 3,500.0 мянган төгрөгийн байгууллагын Төсвийн гүйцэтгэлийн программ, 615.0 мянган төгрөгийн Санхүүгийн тооцоолох ХХК-ийн санхүүгийн программ, 1,750.0 мянган төгрөгийн Си Ти Эс ХХК-ийн санхүүгийн программ, 1,050.0 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн программ, 650.0 мянган төгрөгийн ухаалаг дэлгэцийн программуудыг данс бүртгэлд тусгасан, үйлчилгээний жилийн хураамжид 722.0 мянган төгрөг төлсөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,060,843.2 мянган төгрөг, нийт зарлагыг 1,060,843.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 196,413.7 мянган төгрөгөөр өсгөж, 2025 оны урсгал зардлын төсвийг 1,257,256.9 мянган төгрөгөөр баталж, ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний 11 дүгээр тогтоолоор төсөвт тодотгол хийж 1,318,851.6 мянган төгрөгөөр баталж,

санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,066,720.1 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 1,578,454.2 мянган төгрөг, зарцуулаагүй үлдэгдлээс 963,790.6 мянган төгрөг, нийт 5,927,816.5 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнээс 1,322,180.9 мянган төгрөгөөр хөрөнгө оруулалтын зардлын санхүүжилтийг дутуу олгож 4,605,635.6 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 13 хөтөлбөрийн 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 3,863,549.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үүнээс 1,217,996.7 мянган төгрөгийг урсгал зардлын санхүүжилтээс, 1,856,566.0 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын зардлаас зарцуулж, 788,986.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,074,562.7 мянган төгрөг буюу 86,7 хувьтай байгаа нь нийт зөрүү 1,531,072.9 мянган төгрөгийн санхүүжилтээс 742,086.5 мянган төгрөг нь Сангийн яамнаас зарцуулах эрхийг нээж өгөөгүйгээс зарцуулаагүй, 788,986.4 мянган төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	857,653.50	732,036.76	125,616.74	85.35%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	160,576.00	157,011.68	3,564.32	97.78%
3	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	241,302.50	177,935.66	63,366.84	73.74%
4	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	10,095.00	8,595.00	1,500.00	85.14%
5	71101-Авто зам 80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ 80912-Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах	191,000.00	132,229.82	58,770.18	69.23%
6	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80815-Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	28,716.00	19,958.00	8,758.00	69.50%
7	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80905-Инженерийн шугам сүлжээ, цахилгаан	70,000.00	60,545.71	9,454.29	86.49%
8	71101- Авто зам 80906- Авто зам гүүрний байгууламж	1,783,027.10	1,238,539.26	544,487.84	69.46%
9	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	50,000.00	44,833.90	5,166.10	89.67%

10	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 82801- Улсын баяр наадам	5,000.00	5,000.00	0.00	100.00%
11	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	7,290.00	2,140.00	5,150.00	29.36%
12	71502-Хот байгуулалт тохижилт 80912-Зураг төсөв боловсруулах	200,000.00	0.00	200,000.00	0.00%
13	71502- Хот байгуулалт тохижилт 80905-Инженерийн шугам сүлжээ, цахилгаан 80906-Авто зам, гүүрний байгууламж 80904- Нийгмийн зориулалттай барилга	694,289.70	305,913.87	388,375.83	44.06%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Орон тооны цомхотгол:** Тайлант онд цалингийн зардлыг 26 орон тоотой 782,028.2 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 26 орон тоотой 763,439.9 мянган төгрөг зарцуулсан байна. Гүйцэтгэлээр удирдах 8, гүйцэтгэх 12, үйлчилгээний 6 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж орон тооны цомхотгол хийгээгүй байна.

**Унаа хоол:** Тус байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.2, 8.4 дэх заалт, сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 24-ны Д/11 тоот тогтоолын дагуу нэг хүнд ногдох 1 өдрийн хоолны хөнгөлөлтийг 20.0 мянган төгрөгөөр тооцож 2025 оны төсөвт 62,250.0 мянган төгрөгөөр төсөвлөж 57,994.9 мянган төгрөг зарцуулсан байна.

**Гадаад томилолт, арга хэмжээ:** Тайлант онд гадаад томилолт арга хэмжээний зардал гараагүй байна.

**Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд зарцуулсан зардал:** Тайлант онд сургалт, семинар, зөвлөгөөний зардал гараагүй байна.

**Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрт төлсөн зардал:** Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрт төлсөн зардал гараагүй байна.

**Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал:** Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 279,839.8 мянган төгрөг, байгууллага өөрийн орлогоор 115,491.1 мянган төгрөг, нийт 395,330.9 мянган төгрөгийн санхүүжилт орж ирж цалин хөлс, урамшуулал, НДШ-ийн зардалд 97,236.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 3,041.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 860.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,106.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 180,738.1 мянган төгрөг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 57,009.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 13 хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2025.01.01-2025.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлнэ	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 84.7%	1,423,343.00	1,205,916.70
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2025.01.01-2025.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлнэ.	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 2.1%	101,250.00	2,140.00
3	70709-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	2025.01.01-2025.12.31	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр 99.4%	10,000.00	9,940.00
4	71401- Хог хаягдал	2025.01.01-2025.12.31	Хог хаягдал	Хог хаягдал хөтөлбөр 0%	8,416.80	
5	71502-Хот байгуулалт тохижилт	2025.01.01-2025.12.31	Хот байгуулалт тохижилт	Хот байгуулалт тохижилт хөтөлбөр 44.1%	694,289.70	305,913.87
6	71506-Суурин газрын усан хангамж	2025.01.01-2025.12.31	Суурин газрын усан хангамж	Суурин газрын усан хангамж хөтөлбөр 46.7%	150,000.00	70,049.06
7	71101- Авто зам	2025.01.01-2025.12.31	Авто зам	Авто зам 75.6%	1,812,561.70	1,370,769.07
8	71603-Эрүүл мэндийн бодлого удирдлага	2025.01.01-2025.12.31	Эрүүл мэндийн бодлого удирдлага	Эрүүл мэндийн бодлого удирдлага 99.6%	30,000.00	29,880.00
9	71702- Соёл урлаг	2025.01.01-2025.12.31	Соёл урлагийг дэмжих	Соёл урлагийг дэмжих хөтөлбөр 100%	14,000.00	14,000.00
10	71802-Ерөнхий боловсрол	2025.01.01-2025.12.31	Ерөнхий боловсролыг дэмжих	Ерөнхий боловсролыг дэмжих хөтөлбөр 50.9%	74,711.20	38,000.00
11	71503- Хот суурин ерөнхий төлөвлөгөө	2025.01.01-2025.12.31	Хот суурин ерөнхий төлөвлөгөө	Хот суурин ерөнхий төлөвлөгөө 0%	200,000.00	
12	72101-Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих	2025.01.01-2025.12.31	Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих	Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих 0%	59,091.60	
13	72208-Ахмад настны хөгжил хамгаалал	2025.01.01-2025.12.31	Ахмад настны хөгжил хамгаалал	Ахмад настны хөгжил хамгааллын хөтөлбөр 99.9%	27,971.60	27,954.00
					<b>4,605,635.60</b>	<b>3,074,562.70</b>

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 84,7 хувь, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 2,1 хувь, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр 99,4 хувь, хог хаягдал хөтөлбөр 0 хувь, Хот байгуулалт тохижилт хөтөлбөр 44,1 хувь, суурин газрын усан хангамж хөтөлбөр 46,7 хувь, авто зам хөтөлбөр 75,6 хувь, эрүүл мэндийн бодлого удирдлага хөтөлбөр 99,6 хувь, соёл урлаг хөтөлбөр 100 хувь, ерөнхий боловсрол хөтөлбөр 50,9 хувь, хот суурин ерөнхий төлөвлөгөө хөтөлбөр 0 хувь, жижиг дунд үйлдвэрлэл дэмжих хөтөлбөр 0 хувь, ахмад настны хөгжил хамгаалал 99,9 хувиар хэрэгжсэн нь 2025 оны төсвийн жилд Сангийн яамнаас санхүүжилтийн эрх хааж, үлдэгдэл төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 1,892,424.1 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй 38 бараа, ажил, үйлчилгээний тендерийн зарыг tender.gov.mn цахим хуудсаар зарласан байна. Үүнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 601,000.0 мянган төгрөгийн 3 бараа ажил үйлчилгээ, харьцуулалтын аргаар 715,940.4 мянган төгрөгийн 10 бараа ажил үйлчилгээ, нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар 237,058.7 мянган төгрөгийн 1 ажил, цахим дэлгүүрээс 11,288.0 мянган төгрөгийн 1 бараа, шууд худалдан авах гэрээгээр 323,137.0 мянган төгрөг 22 бараа ажил үйлчилгээ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тусгагдсан байна. Үүнээс нээлттэй сонгон шалгаруултаар шалгарсан замын зураг төсөв 161,379.3 мянган төгрөг, харьцуулалтын аргаар шалгарсан түлш шатахуун 31,000.0 мянган төгрөг, байгууллагуудын сантехникийн засвар 94,574.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж 29,880.0 мянган төгрөг, худаг барих 47,822.7 мянган төгрөг, Наадмын талбайн хашаа хийх ажил 94,827.7 мянган төгрөг, үерийн далан хийх ажил 95,640.1 мянган төгрөг, цахим дэлгүүр болон шууд худалдан авах аргаар хийгдсэн ЗДТГ-ын тоног төхөөрөмж 10,950.0 мянган төгрөг, нормын хувцас 3,000.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 3,500.0 мянган төгрөг, Соёлын төвийн техник хэрэгсэл 14,000.0 мянган төгрөг, дунд сургуулийн тохижилтын ажил 20,000.0 мянган төгрөгөөр тус тус гэрээ хийгдэж 4 бараа ажил үйлчилгээний 186,746.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу хийгдэж өглөгөөр дансанд бүртгэсэн байна. Энэ нь Сангийн яамнаас жилийн эцэст хөрөнгө оруулалтын санхүүжилтийг царцаасантай холбоотой байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Хатанбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлага 5,835,727.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 87,535.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 65,651.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор 13 хөтөлбөрийн 20 арга хэмжээнээс хэмнэгдсэн 788,986.4 мянган төгрөгийн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-дэх заалтыг хэрэгжүүлэн албан ажлын 4 суудлын автомашинд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар авсан байна. Мөн захиргааны зориулалтаар барилга байгууламж шинээр төсвийн хөрөнгөөр бэлтгээгүй, албан хаагчдад дүрэмт хувцас болон нормын хувцас бэлтгээгүй, албан хаагчдын гар утасны зардал болон байгууллага дээр хэвлэл захиалгын зардал зэргийг санхүүжүүлээгүй, худалдан авах ажиллагааны тендер зарлаж 2025 оны 05 дугаар сарын 31 гэхэд дуусгавар болгосон, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулаагүй бөгөөд хэмнэлтэд тооцож төсөвт төвлөрүүлсэн зэрэг Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд байршуулбал зохих 181 мэдээллээс, хугацаа болоогүй 4 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл, хугацаандаа байршуулсан 170 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 96 хувьтай байна. Энэ нь Шилэн дансны тухайн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 -д “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага хүргүүлнэ гэж заасны дагуу шийдвэрлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, горим, сорил хэрэгжүүлсэн. Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 30,249.5 мянган төгрөгийн алдаа илэрснээр 4 зөвлөмж өгч, жилийн эцсээр 30,249.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2024 оны санхүүгийн тайлангийн 4 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 4 зөвлөмж өгөгдсөнийг 75 хувь хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 03/150 тоотой ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	1,447.8	2	534.1	50
Албан шаардлага	3	73,191.2	3	73,191.2	100
Зөвлөмж	4	220,437.0	3	220,437.0	75
Нийт дүн	11	295,076.0	8	294,162.3	75,0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн заавар, журам шинэчлэгдсэнийг хэрэгжүүлж байгаа эсэхийг авч үзнэ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,050,740.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс, аудитын явцад 5,050,740.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,050,740.9 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

1. Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 4,976,941.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг бөөн дүнгээр тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Үлдэх өртөгтэй 58,880.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллага уруу шилжүүлэхдээ буруу бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Үнэ төлбөргүй авсан 13,919.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн сайжруулалтыг хийхдээ орлогын зүйлийг буруу сонгож бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 31,338.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 65,651.9 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 31,338.7 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 6,038.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 11,220.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 14,080.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлангаар (ТТ-11) татвараас авах авлагыг 6,038.3 мянган төгрөгөөр үүсгэж, тус авлагын дүнг санхүүгийн тайланд тусгаагүй, тооцоо нийлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-д “Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

### **5.2 Албан шаардлага**

1. Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн Засаг даргын орлогчид 11,220.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр

хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 -д "хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" бол албан шаардлага хүргүүлнэ" гэж заасны дагуу шийдвэрлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Цалин урамшуулалтай холбоотой асуудал

1. Тамгын даргад төрийн захиргааны албан хаагчийн 5 жилийн урамшуулал 7,095,0 мянган төгрөг олгож татвар суутгасан боловч татварын (ТТ-11) тайланд тусгаагүй, суутгасан орлогыг өөр татварын төрлийн дансанд шилжүүлсэн, мөн ахмадын зөвлөлийн даргад 6,985.4 мянган урамшуулал олгохдоо татвар суутгасан боловч татварын(ТТ-11) тайлан тусгаагүй зөрчлүүд тус тус илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-д "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах" гэж заасныг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Цалингийн Т-11 тайлангийн засварлах хүсэлт явуулж тайлангаа засварлах, буруу татварын төрлөөр шилжүүлсэн орлогыг Татварын газартай тооцоо нийлж суутган тооцоолол хийх.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалыг бөөн дүнгээр тайлагнасан.	1	4,976,941.4			1	4,976,941.4	1	4,976,941.4
Үлдэх өртөгтэй 58,880.0 төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллага уруу шилжүүлэхдээ буруу бичилт хийсэн.	1	58,880.0			1	58,880.0		58,880.0
Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийн сайжруулалтыг хийхдээ орлогын	1	13,919.5			1	13,919.5		13,919.5

зүйлийг буруу сонгож бүртгэсэн.								
Дүн	3	5,050,740.9			3	5,050,740.9	1	5,050,740.9

## 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Татварын тайлангаар (ТТ-11) татвараас авах авлагыг 6,038.3 мянган төгрөгөөр үүсгэсэн.	1	6,038.3	1	6,038.3								
Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн Засаг даргын орлогчид мөнгөн тэтгэмж олгосон байна.	1	11,220.0			1	11,220.0						
Урамшуулалд олгохдоо татвар суутгасан боловч татварын тайлан тусгаагүй зөрчлүүд илэрсэн	1	14,080.4					1	14,080.4				
Дүн	3	31,338.7	1	6,038.3	1	11,220.0	1	14,080.4				

## 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 177 мэдээлэл оруулахаас 170 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 7 мэдээлэл хоцроосон байна.	1	0			1	0		
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	0	0					0	0
Дүн	0	0					0	0
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)